



**ИНД - 109**

Иргэний Нисэхийн Дүрэм

**Зохицуулалттай агаарын ачааны байгууллага -  
Гэрчилгээжүүлэлт**

Иргэний нисэхийн ерөнхий газар

## **ДҮРМИЙН ТАЙЛБАР**

ИНД-109 нь Зохицуулалттай агаарын ачааны байгууллагын гэрчилгээжүүлэлтийн болон үйл ажиллагааны шаардлагыг тогтооно.

Энэ Дүрэм нь дараах зорилгоор олон улсын зорчигч тээврийн агаарын хөлгөөр тээвэрлэх ачаа болон шууданд хамаарах аюулгүйн хамгаалалтын хяналтыг тогтооно:

- олон улсын зорчигч тээврийн агаарын хөлгийн зорчигч болон хөлгийн багийг зохих түвшний хамгаалалтаар хангах;
- Монгол Улс нь ачааны аюулгүй эх үүсвэр гэдэг нэр хүндийг олон улсын нисэхийн хамтрагчдад бататгах;
- Монгол Улсаас болон Монгол Улсад иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтыг бататгахад чиглэсэн, Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцийн Хавсралт 17-гийн (Аюулгүйн хамгаалалт) дагуу олон улсын гэрээний үүргийг биелүүлэх.

ИНД-109 нь хууль бус үйлдэл хийхэд ашиглаж болох зэвсэг, тэсрэх бодис, эсхүл бусад эд зүйл, эсхүл бодисыг олон улсын зорчигч тээврийн агаарын хөлөгт ачаа, эсхүл шуудан хэлбэрээр ачихаас аль болох боломжит хэлбэрээр урьдчилан сэргийлэх зорилготой.

**Энэ Дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан ИНД-109-ийн цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-109, түүний нэмэлт, өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл [www.mcaa.gov.mn](http://www.mcaa.gov.mn) веб сайтаас татаж авах боломжтой.**

**Мэдээлэл**

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн дүрмийг боловсруулсан.

**Өөрчлөлтийн түүх****Хүчинтэй огноо**

Анхны боловсруулалт

2002 оны 12 сарын 20

Нэмэлт, өөрчлөлт 1 (Шинэчлэлт)

2018 оны ... сарын ...

**Тэмдэглэл:** ИНД-109-ийн шинэчлэлтийг монгол, англи хэл дээр, NZ Part 109 A.0-д үндэслэн боловсруулсан болно.

## Гарчиг

<b>А Бүлэг - Ерөнхий зүйл</b> .....	<b>5</b>
109.1. Зорилго.....	5
109.3. Тодорхойлолт.....	5
109.5. Гэрчилгээжих шаардлага.....	5
109.7. Гэрчилгээ эзэмших хүсэлт.....	5
109.9. Гэрчилгээ олгох.....	5
109.11. Гэрчилгээ эзэмшигчийн эрх.....	6
109.13. Гэрчилгээний хугацаа.....	6
109.15. Гэрчилгээ сунгах.....	6
<b>В Бүлэг - Гэрчилгээжүүлэлтийн шаардлага</b> .....	<b>6</b>
109.51. Ажилтанд тавих шаардлага.....	6
109.53. Байгууламжийн шаардлага.....	7
109.55. Ачаа болон шуудангийн аюулгүйн хамгаалалтын хяналтын журам.....	7
109.57. Аюулгүйн үзлэгийн журам.....	8
109.59. Зөвшөөрөл олгох журам.....	8
109.61. Бүртгэлтэй харилцагчийн журам болон бүртгэл.....	10
109.63. Ажилтнуудын сургалт.....	10
109.65. Ачааны аюулгүйн хамгаалалтын зөрчил.....	11
109.67. Бүртгэл хөтлөх.....	11
109.69. Дотоод чанар баталгаажуулалт.....	12
109.71. Байгууллагын Ерөнхий заавар.....	13
<b>С Бүлэг - Үйл ажиллагааны шаардлага</b> .....	<b>15</b>
109.101. Байнгын хэрэгжилт.....	15
109.103. Бүртгэлтэй харилцагчийн нэрийг түдгэлзүүлэх, эсхүл хасах.....	15
109.105. Гэрчилгээ эзэмшигчийн байгууллагын өөрчлөлт.....	16
109.107. Аюулгүйн хамгаалалтын мэдүүлэг гаргах этгээд.....	17
109.109. Хяналттай нэвтрэх бүс рүү нэвтрэх.....	17
<b>Хавсралт А - Аюулгүйн хамгаалалтын мэдүүлэг</b> .....	<b>18</b>
А.1. Аюулгүйн хамгаалалтын мэдүүлэг.....	18
<b>Хавсралт В - Аюулгүйн үзлэгийн стандарт</b> .....	<b>18</b>
В.1. Аюулгүйн үзлэгийн арга.....	18
В.2. Үечилсэн сорилт.....	19
<b>Хавсралт С - Сургалтын Стандарт</b> .....	<b>19</b>
С.1. Үнэлгээний тогтолцоо болон сургалт.....	19

## А Бүлэг - Ерөнхий зүйл

### 109.1. Зорилго

(а) Энэ Дүрэм нь зорчигч тээвэрлэж байгаа агаарын хөлгөөр тээвэрлэхэд аюулгүйн хамгаалалтын мэдүүлэг дагалдуулахыг шаардсан ачаа, эсхүл шуудангийн үйлчилгээ үзүүлэх Зохицуулалттай агаарын ачааны байгууллагын (цаашид ЗААБ гэх) гэрчилгээжүүлэлтийн болон үйл ажиллагааны шаардлагыг тогтооно.

(б) Энэ Дүрэмд, агаараар тээвэрлэхээр зорьж байгаа ачаа, эсхүл шуудантай холбоотой аливаа шаардлага нь зөвхөн олон улсын тогтмол агаарын тээврийн зорчигч үйлчилгээ үзүүлж байгаа агаарын хөлгөөр тээвэрлэх ачаа, эсхүл шууданд хамаарна.

### 109.3. Тодорхойлолт

Энэ Дүрэмд:

**Хяналттай нэвтрэх бүс** гэж тодорхой бүсийн хувьд зөвшөөрөгдөөгүй аливаа этгээд нэвтрэхээс сэргийлж, хамгаалагдсан бүсийг.

### 109.5. Гэрчилгээжих шаардлага

Хэрэв ачаа, эсхүл шууданг олон улсын тогтмол агаарын тээврийн зорчигч үйлчилгээ үзүүлж байгаа агаарын хөлөгт тээвэрлэх бол энэ Дүрмийн дагуу олгосон ЗААБ-ын гэрчилгээнд зааснаас бусад тохиолдолд аливаа этгээдийг ачаа, эсхүл шуудангаар илгээх барааг агаараар тээвэрлүүлэхээр агаарын тээвэрлэгчид хүлээлгэн өгөхийг хориглоно.

### 109.7. Гэрчилгээ эзэмших хүсэлт

ЗААБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь САА 24109/01 маягыг бөглөн, дараах баримт бичгийн хамт Даргад хүргүүлнэ:

- (1) 109.71-д шаардсан Ерөнхий заавар;
- (2) хэрэв хамааралтай бол зохих төлбөрийн баримт.

### 109.9. Гэрчилгээ олгох

Хэрэв Дарга дараах шаардлага хангагдсан гэж үзвэл хүсэлт гаргагчид ЗААБ-ын гэрчилгээ олгоно:

- (1) энэ дүрмийн В Бүлгийн шаардлагыг хангасан байх;
- (2) 109.51-д шаардсан, тухайн хүсэлт гаргагч болон хүсэлт гаргагчийн удирдах ажилтан, эсхүл ажилтнууд нь тохирох зөв хүн байх;
- (3) тухайн гэрчилгээг олгох нь нисэхийн аюулгүй байдал, эсхүл аюулгүйн хамгаалалтын ашиг сонирхолд харшлахгүй байх.

**109.11. Гэрчилгээ эзэмшигчийн эрх**

ЗААБ-ын гэрчилгээ нь түүнийг эзэмшигчид олон улсын тогтмол агаарын тээврийн зорчигч үйлчилгээ үзүүлж байгаа агаарын хөлгөөр тээвэрлэх ачаа, эсхүл шуудангаар илгээх бараанд ЗААБ-ын аюулгүйн хамгаалалтын мэдүүлэг гаргах эрх олгоно.

**109.13. Гэрчилгээний хугацаа**

- (a) ЗААБ-ын гэрчилгээг максимум 5 жилийн хугацаагаар олгож, эсхүл сунгаж болно.
- (b) ЗААБ-ын гэрчилгээ нь түүний хугацаа дуусах, эсхүл түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох хүртэл хүчинтэй хэвээр байна.

**109.15. Гэрчилгээ сунгах**

ЗААБ-ын гэрчилгээний хугацаа сунгуулах хүсэлтийг, тухайн гэрчилгээнд заасан сунгах хугацаанаас өмнө, эсхүл хэрэв сунгах хугацааг заагаагүй бол гэрчилгээний хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө Даргад хүргүүлэх үүрэгтэй.

**В Бүлэг - Гэрчилгээжүүлэлтийн шаардлага****109.51. Ажилтанд тавих шаардлага**

(a) ЗААБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах ажилтныг үндсэн ажилтнаар, гэрээгээр, эсхүл бусад хэлбэрээр авч ажиллуулах үүрэгтэй:

- (1) гүйцэтгэх захирлаар тодорхойлогдсон дараах удирдах ажилтан:
  - (i) тухайн байгууллагын гүйцэтгэж байгаа бүх үйл ажиллагааг санхүүжүүлж, энэ Дүрэмд заасан үйл ажиллагааны шаардлагын дагуу гүйцэтгэж чадахаа тухайн хүсэлт гаргагчийн байгууллагын хүрээнд бататгах эрхтэй;
  - (ii) тухайн байгууллага нь энэ Дүрмийн шаардлагыг хангаж байгааг бататгах үүрэг хариуцлага хүлээсэн;
- (2) гүйцэтгэх захирлын өмнө тухайн хүсэлт гаргагчийн байгууллага Ерөнхий зааврын шаардлагыг хангаж байгааг бататгах удирдах ажилтан, эсхүл ажилтнууд;
- (3) Ерөнхий зааварт дэлгэрэнгүй тусгасан, ачаа болон шуудангийн аюулгүйн хамгаалалтын хяналтын журмыг хэрэгжүүлэх хангалттай тооны ажилтан.

(b) ЗААБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, тухайн байгууллагын Ерөнхий зааварт заасны дагуу ачаа, эсхүл шуудангийн аюулгүйн хамгаалалтын хяналттай холбоотой ажил үүрэг гүйцэтгэх эрх олгогдсон ажилтнуудын ур чадварын үнэлгээ хийх, түүнийг хадгалах журмыг тогтоох үүрэгтэй.

**109.53. Байгууламжийн шаардлага**

ЗААБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, тухайн байгууллагын үзүүлэх үйлчилгээтэй холбоотой дараах ажиллагаанд тохирсон байгууламжтай байх үүрэгтэй:

- (1) бүртгэлгүй харилцагчаас ачаа, эсхүл шууданг хүлээн авах болон аюулгүйн хамгаалалтын хяналтад хамруулах;
- (2) бүртгэлтэй харилцагчаас ачаа, эсхүл шуудангаар илгээх барааг хүлээн авах, тухайн илгээх бараа болон холбогдох баримт бичгийг шалгах;
- (3) тухайн илгээх бараанд гэмтэл учруулахаас хамгаалах зорилгоор шаардлагатай аюулгүйн хамгаалалтын хяналт тавьсан ачаа, эсхүл шуудангаар илгээх барааг хяналттай нэвтрэх бүсэд хадгалах;
- (4) тухайн илгээх бараанд гэмтэл учруулаагүй болохыг бататгах аргыг багтаасан, ЗААБ-ын хяналттай нэвтрэх агуулахын бүсээс ачаа, эсхүл шуудангаар илгээх барааг агаарын тээвэрлэгчид хүргэх.

**109.55. Ачаа болон шуудангийн аюулгүйн хамгаалалтын хяналтын журам**

(a) ЗААБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах зүйлийг бататгах аюулгүйн хамгаалалтын хяналтын журмыг тогтоох үүрэгтэй:

- (1) бүртгэлгүй харилцагчаас агаараар тээвэрлэхээр хүлээн авсан ачаа, эсхүл шуудангаар илгээх бараа бүрд хууль бус үйлдэл хийхэд ашиглаж болох зэвсэг, тэсрэх бодис, эсхүл бусад аюултай хэрэгсэл, эд зүйл, эсхүл бодис нэвтрүүлэхээс сэргийлэх зорилгоор аюулгүйн хамгаалалтын хяналт тавьсныг;
- (2) бүртгэлтэй харилцагчаас агаараар тээвэрлүүлэхээр хүлээн авсан ачаа, эсхүл шуудангаар илгээх бараа бүрийг:
  - (i) агууламжийн мэдэгдэл дагалдсаныг;
  - (ii) тухайн илгээх бараанд гэмтэл учруулаагүй болохыг бататгах зорилгоор шалгасныг;
- (3) энэ хэсгийн (2)-ын дагуу шаардсан ачаа, эсхүл шуудангаар илгээх бараа бүрийн агууламжийн мэдэгдлийг дараах зорилгоор шалгасныг:
  - (i) тухайн ачаа, эсхүл шуудангаар илгээх бараанд хууль бус үйлдэл хийхэд ашиглаж болох зэвсэг, тэсрэх бодис, эсхүл бусад аюултай хэрэгсэл, эд зүйл, эсхүл бодис байхгүй болохыг бататгах;
  - (ii) тухайн агууламжийн мэдэгдэл нь бүртгэлтэй харилцагчаас гаралтай болохыг бататгах;
- (4) тухайн ЗААБ-ын хүлээн авсан болон энэ хэсгийн (1), эсхүл (2) болон (3)-ын дагуу түүнд хамааралтай аюулгүйн хамгаалалтын хяналт хийгдсэн, ачаа, эсхүл шуудангаар илгээх бараа бүрийг түүнийг тээвэрлэх агаарын тээвэрлэгчид хүргүүлэн, агаарын хөлөгт ачих хүртэл хяналттай нэвтрэх бүсэд хадгалсан болохыг;

- (5) агаарын хөлгөөр тээвэрлүүлэхээр тухайн агаарын тээвэрлэгчид хүргүүлсэн ачаа, эсхүл шуудангаар илгээх бараа бүрийг:
- (i) Хавсралт А.1-д заасан шаардлагыг хангасан аюулгүйн хамгаалалтын мэдүүлэг дагалдсан бөгөөд 109.59-ийн дагуу тухайн аюулгүйн хамгаалалтын мэдүүлэгт эрх бүхий этгээд гарын үсэг зурсан болохыг;
  - (ii) тухайн илгээх бараа нь ЗААБ-ын хяналттай нэвтрэх бүсийг орхих үеэс, агаарын тээвэрлэгч тухайн илгээх барааг хүлээн авах хүртэл гэмтэл учруулах аливаа үйлдлээс хамгаалагдсаныг.
- (b) Энэ зүйлийн (a)-д шаардсан аюулгүйн хамгаалалтын хяналтын журмыг хэрэгжүүлэх этгээд нь зохих ёсоор сургалтад хамрагдсан бөгөөд 109.59-ийн дагуу олгосон зохих зөвшөөрөл эзэмшдэг байх үүрэгтэй.

### **109.57. Аюулгүйн үзлэгийн журам**

- (a) Энэ дүрмийн 109.55-д шаардсан аюулгүйн хамгаалалтын хяналтын журмын хэсэг болох ачаа, эсхүл шуудангийн аюулгүйн үзлэг хийхээр зорьж байгаа ЗААБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь Хавсралт В-гийн дагуу аюулгүйн үзлэгийн журмыг тогтоох үүрэгтэй.
- (b) Энэ зүйлийн (a)-д шаардсан журам нь дараах шаардлагыг багтаасан байх ёстой:
- (1) тухайн аюулгүйн үзлэгт хэрэглэх аргыг таньж тогтоох ба тохирсон байх;
  - (2) аюулгүйн үзлэг гүйцэтгэж байгаа этгээдийн заавал дагаж мөрдөх ажиллагаа бүрийг дэлгэрэнгүй заасан байх;
  - (3) тодорхой аюулгүйн үзлэгийн аргын хувьд аливаа этгээд нь 109.59-ийн дагуу зохих ёсоор зөвшөөрөгдсөн байхыг шаардсан байх;
  - (4) тухайн аюулгүйн үзлэг гүйцэтгэж байгаа этгээдийг хамруулсан, аюулгүйн үзлэгийн аргад, үечлэлтэйгээр сорилт хийх журам болон хөтөлбөрийг багтаасан байх;
  - (5) техникийн төхөөрөмж ашигладаг аюулгүйн үзлэгийн аргын хувьд тухайн төхөөрөмжийн засвар үйлчилгээний хөтөлбөрийг багтаах, хэрэв хамааралтай бол тухайн аюулгүйн үзлэгийн төхөөрөмжийн тохиролд үечлэлтэйгээр сорилт хийх журмыг багтаасан байх;
  - (6) аюулгүйн үзлэгийн аргын алдаанаас үүсэх үр дагаварт үнэлгээ хийх үйл явц болон өмнө нь аюулгүйн үзлэг хийсэн ачаанд тухайн алдааны үзүүлж болох нөлөөллийн талаар авах арга хэмжээг багтаасан байх.

### **109.59. Зөвшөөрөл олгох журам**

- (a) ЗААБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь тухайн байгууллагын санал болгосон ажиллагаанд хамаарах, дараах аюулгүйн хамгаалалтын хяналтын үүрэг гүйцэтгэх этгээд бүрд зөвшөөрөл олгох журмыг тогтоох үүрэгтэй:
- (1) 109.57-д шаардсан журмын дагуу ачаа, эсхүл шууданд аюулгүйн үзлэг хийх;



- (2) 109.55(а)(1)-д шаардсан аюулгүйн хамгаалалтын хяналтын журмыг бүртгэлгүй харилцагчаас хүлээн авсан ачаа, эсхүл шууданд хэрэгжүүлэх;
  - (3) 109.55(а)(2) болон (а)(3)-т шаардсан аюулгүйн хамгаалалтын хяналтын журмын дагуу, бүртгэлтэй харилцагчаас хүлээн авсан ачаа, эсхүл шуудангаар илгээх бараа болон агууламжийн мэдэгдлийг шалгах;
  - (4) 109.55(а)(4)-т заасан, тухайн хүсэлт гаргагчийн хяналттай нэвтрэх бүсэд хадгалагдаж байгаа ачаа, эсхүл шуудангаар илгээх барааг шалгах;
  - (5) 109.55(а)(5)(i)-д шаардсан аюулгүйн хамгаалалтын мэдүүлгийг ачаа, эсхүл шуудангаар илгээх бараа бүрд гаргах;
  - (6) 109.55(а)(5)(ii)-т шаардсан аюулгүйн хамгаалалтын хяналтын журмын дагуу гэмтэл учирсан (tamper evident) хэлбэрээр агаарын тээвэрлэгчид хүргэгдээгүй боловч аюулгүйн хамгаалалтын мэдүүлэг дагалдсан ачаа, эсхүл шуудангаар илгээх барааг хүргэх;
  - (7) 109.61(а)-д шаардсан бүртгэлтэй харилцагчийн журмыг хэрэгжүүлэх болон бүртгэлтэй харилцагчийн дэлгэрэнгүй мэдээллийг 109.61(с)-д шаардсан бүртгэлд оруулах.
- (b) ЗААБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь 109.109(2)-т зааснаас бусад, хяналттай нэвтрэх бүсэд орох аливаа этгээдэд зөвшөөрөл олгох журмыг тогтоох үүрэгтэй.
- (c) Энэ зүйлийн (a) болон (b)-д шаардсан журам нь дараах шаардлагыг багтаасан байх ёстой:
- (1) дараахаас бусад тохиолдолд аливаа этгээдэд зөвшөөрөл олгохыг хориглох:
    - (i) тухайн этгээд аюулгүйн хамгаалалтын шалгалт гүйцэтгэх чадвартай талаар Дарга эерэг тодорхойлолт өгсөн байх;
    - (ii) энэ зүйлийн (a)-ийн дагуу олгох зөвшөөрлийн хувьд тухайн этгээд нь 109.63-т шаардсан ЗААБ-ын сургалтын хөтөлбөрийн дагуу зохих ёсоор сургалтад хамрагдсан байх;
    - (iii) энэ зүйлийн (a)-ийн дагуу олгох зөвшөөрлийн хувьд тухайн этгээд нь 109.63-т шаардсан ЗААБ-ын сургалтын хөтөлбөрийн дагуу, тухайн зорьж байгаа зөвшөөрлийн хүрээнд аюулгүйн хамгаалалтын хяналтын үүрэг гүйцэтгэх зорилгоор ур чадварын үнэлгээ хийлгэсэн байх;
    - (iv) энэ зүйлийн (b)-ийн дагуу олгох зөвшөөрлийн хувьд тухайн этгээд нь агаарын ачааны аюулгүйн хамгаалалтын шаардлагын талаар мэдлэгтэй байх;
  - (2) аливаа зөвшөөрөл нь бичгээр байх ба дараах мэдээллийг агуулсан байх:
    - (i) тухайн зөвшөөрөл олгогдсон этгээдийн нэр;
    - (ii) тухайн этгээдэд гүйцэтгэхийг зөвшөөрсөн аюулгүйн хамгаалалтын хяналтын үүрэг, эсхүл бусад үүрэг;
    - (iii) тухайн зөвшөөрлийн дуусах хугацаа;

- (3) зөвшөөрлийг 3 жилээс дээш хугацаагаар олгохыг хориглох;
- (4) энэ хэсгийн (1), (2) болон (3)-т заасан шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд аливаа этгээдэд дахин зөвшөөрөл олгохыг хориглох.

#### **109.61. Бүртгэлтэй харилцагчийн журам болон бүртгэл**

(a) Бүртгэлтэй харилцагчаас агаараар тээвэрлүүлэх ачаа, эсхүл шуудан хүлээн авахаар зорьж байгаа ЗААБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах журмыг тогтоох үүрэгтэй:

- (1) бүртгэлтэй харилцагчийн ачаа, эсхүл шууданг агаараар тээвэрлүүлэхтэй холбоотой аюулгүйн хамгаалалтын талаар мэдлэгтэй болохыг бататгах;
- (2) тухайн бүртгэлтэй харилцагч нь дараах тогтолцоо болон журмыг тогтоосныг бататгах:
  - (i) тухайн хүсэлт гаргагчийн байгууллагад агаараар тээвэрлүүлэхээр хүргүүлж байгаа харилцагчийн ачаа, эсхүл шуудангаар илгээх бараанд зөвхөн ачаа, эсхүл шуудангийн зориулалттай эд зүйлс агуулагдсаныг;
  - (ii) тухайн хүсэлт гаргагчийн байгууллагад хүргүүлсэн ачаа, эсхүл шуудангаар илгээх бараа бүрд, бүртгэлтэй харилцагчаас гаралтай болохыг таньж тогтоох агууламжийн мэдэгдэл дагалдсаныг;
  - (iii) тухайн хүсэлт гаргагчийн байгууллагад хүргүүлсэн аливаа ачаа, эсхүл шуудангаар илгээх барааг, гэмтэл учруулсан эсэхийг тогтооход хялбар хэлбэрээр хамгаалсныг;
  - (iv) бүртгэлтэй харилцагч тухайн ачаа, эсхүл шууданг хүсэлт гаргагчийн байгууллагад илгээх үед гэмтэл учраагүй болохыг.

(b) Энэ зүйлийн (a)-ийн дагуу шаардсан журамд, тухайн хүсэлт гаргагчийн байгууллага нь энэ зүйлийн (a)-ийн шаардлагыг тасралтгүй хангаж байгааг бататгах арга хэлбэрийг багтаасан байх ёстой.

(c) Энэ зүйлийн (a)-д шаардсан журмын дагуу бүртгэлтэй харилцагчаас агаараар тээвэрлэхээр ачаа, эсхүл шуудангаар илгээх бараа хүлээн авахаар зорьж байгаа ЗААБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах бүртгэлийг хөтлөх үүрэгтэй:

- (1) харилцагчийн албан ёсны нэр (хэрэв хамааралтай бол бизнесийн нэр);
- (2) холбоо барих ажилтны нэр болон дэлгэрэнгүй мэдээлэл;
- (3) харилцагчийн хаяг, холбогдох факс, цахим шуудан болон утасны дугаар.

#### **109.63. Ажилтнуудын сургалт**

(a) ЗААБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах сургалтын хөтөлбөрийг боловсруулах үүрэгтэй:

- (1) тухайн хүсэлт гаргагчийн байгууллагын агаараар тээвэрлэхээр хүлээн авсан ачаа, эсхүл шуудангаар илгээх бараатай харьцах этгээд бүр, илгээх барааны хадгалалт болон тээвэрлэлтийн аюулгүйн хамгаалалтын хяналтын журмын холбогдох сургалтад хамрагдсаныг бататгах;
  - (2) тухайн хүсэлт гаргагчийн байгууллагын агаараар тээвэрлэхээр хүлээн авсан ачаа, эсхүл шуудантай холбоотой аюулгүйн хамгаалалтын хяналтын үүрэг гүйцэтгэдэг аливаа этгээдийг зохих сургалтад хамруулсан бөгөөд аюулгүйн хамгаалалтын хяналтын үүрэг гүйцэтгэх ур чадварын үнэлгээ хийснийг бататгах.
- (b) Энэ зүйлийн (a)-д шаардсан сургалтын хөтөлбөр нь:
- (1) дараах үе шатуудыг:
    - (i) анхан шатны сургалтын;
    - (ii) давтан сургалтын;
    - (iii) ур чадварын үнэлгээний;
  - (2) аюулгүйн хамгаалалтын хяналтын үүрэг болон сургалтын үе шат бүрд холбоотой хичээлийн сэдвийг агуулсан байх ёстой
- (c) Энэ зүйлийн (a)-д шаардсан сургалтын хөтөлбөр нь, сургалтад хамрагдах шаардлагатай этгээд бүр, 3 жилээс дээшгүй хугацаанд тухайн сургалтын хөтөлбөрийн давтан сургалтын үе шатанд хамрагдахыг бататгах ёстой.
- (d) Аюулгүйн үзлэгийг багтаасан, аюулгүйн хамгаалалтын хяналтын үүрэг гүйцэтгэдэг этгээдэд зориулсан сургалтын хөтөлбөр нь Хавсралт С-д заасан стандартыг багтаасан байх ёстой.

#### **109.65. Ачааны аюулгүйн хамгаалалтын зөрчил**

ЗААБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах журмыг тогтоох үүрэгтэй:

- (1) тухайн байгууллагын ажиллагаатай холбоотой ачааны аюулгүйн хамгаалалтын зөрчлийг ИНД-12-ын дагуу мэдээлэх, шинжлэн шалгах болон тайлагнах;
- (2) ачааны аюулгүйн хамгаалалтын зөрчлийн шалтгааныг арилгах, залруулах арга хэмжээг хэрэгжүүлэх болон зөрчил давтагдахаас урьдчилан сэргийлэх.

#### **109.67. Бүртгэл хөтлөх**

(a) ЗААБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь бүртгэлийг таньж тогтоох, цуглуулах, индексжүүлэх, хадгалах, хөтлөх болон устгах үйл явцыг багтаасан, үнэн зөв бүртгэлээр хангахад шаардлагатай дараах бүртгэлийн журмыг тогтоох үүрэгтэй:

- (1) мэдүүлгийн хувийг багтаасан аюулгүйн хамгаалалтын мэдүүлгийн зөвшөөрлийн хүрээнд агаараар тээвэрлүүлэхээр агаарын тээвэрлэгчид хүргүүлсэн ачаа, эсхүл шуудангаар илгээх бараа бүрийн;
- (2) хамрагдсан сургалтын үе шат бүрийн дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан, 109.63-т шаардсан сургалтад хамрагдсан байх шаардлагатай этгээд бүрийн;

- (3) 109.59(с)(1)(i)-д шаардсан, тухайн этгээдийн сургалт болон ур чадварын үнэлгээ, зөвшөөрлийн дэлгэрэнгүй мэдээлэл, аюулгүйн хамгаалалтын шалгалтын тодорхойлолтыг багтаасан, 109.59-ийн дагуу бичгээр зөвшөөрөл олгосон этгээд бүрийн;
- (4) 109.61(с)-д шаардсан байнгын хэрэгжилтийн дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан, 109.61(b)-д шаардсан бүртгэлд орсон бүртгэлтэй харилцагч бүрийн;
- (5) 109.65-ын дагуу гүйцэтгэсэн ачааны аюулгүйн хамгаалалтын зөрчлийг шинжлэн шалгахтай холбоотой шинжлэн шалгах ажиллагаа бүрийн;
- (6) 109.69-ийн дагуу гүйцэтгэсэн дотоод чанар баталгаажуулалтын үнэлгээ бүрийн.
- (b) Энэ зүйлийн (a)-ийн дагуу шаардсан бүртгэл нь дараах шаардлагыг хангах ёстой:
- (1) үнэн зөв, гаргацтай, байнгын хувиршгүй хэлбэрээр хөтлөх;
- (2) нисэхийн аюулгүйн хамгаалалтын ашиг сонирхлын үүднээс:
- (i) энэ зүйлийн (a)(2) болон (3)-т шаардсан бүртгэлийн хувьд ажилтан ажлаас халагдсан, эсхүл ЗААБ-тай холбоотой байсан хугацаанаас хойш максимум 2 жилийн хугацаанд хадгалах;
- (ii) агууламжийн мэдэгдэл, эсхүл аюулгүйн хамгаалалтын мэдүүлгийн хувьд Дарга, аюулгүйн хамгаалалтын зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны зорилгоор урт хугацаа шаардсанаас бусад тохиолдолд 31 хоногоос доошгүй хугацаанд хадгалах.

### **109.69. Дотоод чанар баталгаажуулалт**

- (a) ЗААБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь энэ Дүрмээр шаардсан журмын хэрэгжүүлэлт болон дүрмийн нийцлийг бататгах дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэх үүрэгтэй.
- (b) Дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоо нь дараах журмыг багтаах ёстой:
- (1) 109.65-ын дагуу шинжлэн шалгасан ачааны аюулгүйн хамгаалалтын аливаа зөрчлийн шалтгааныг арилгах, давтагдахаас сэргийлэх, залруулах арга хэмжээний журмыг агуулсан аюулгүйн хамгаалалтын бодлого болон аюулгүйн хамгаалалтын бодлогын журам;
- (2) дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоон дахь хүндрэлтэй асуудал, эсхүл хүндрэлтэй асуудлын бодит шалтгааныг тогтоох зорилгоор аюулгүйн хамгаалалтын хяналтын зөрчлийн давтамж, ажилтнууд болон харилцагчийн санал хүсэлтийг багтаасан чанарын үзүүлэлтүүдийг хянах журам;
- (3) дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоонд илрүүлсэн хүндрэлтэй асуудлыг засаж залруулах арга хэмжээний журам;
- (4) дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоонд илрүүлсэн хүндрэлтэй асуудлын бодит шалтгааныг арилгасныг бататгах урьдчилан сэргийлэх арга хэмжээний журам;

- (5) тухайн хүсэлт гаргагчийн байгууллагын үйл ажиллагаа нь Ерөнхий заавартаа агуулагдсан журмуудад нийцэж байгааг болон аюулгүйн хамгаалалтын бодлогод тодорхойлсон зорилгод хүрэхийг бататгах дотоод аудитын хөтөлбөр;
  - (6) дотоод чанар баталгаажуулалтын тогтолцооны байнгын тохирол болон үр дүн нь энэ Дүрмийн шаардлагад нийцэж байгааг бататгах, хэрэв хамааралтай бол статистикийн судалгааг хэрэглэх шаардлагыг багтаасан удирдлагын үнэлгээний журам.
- (с) Дотоод чанар баталгаажуулалтын үүрэг хариуцлага хүлээсэн удирдах ажилтан нь агаараар тээвэрлэх ачаа, эсхүл шуудангийн аюулгүйн хамгаалалтад нөлөөлөх асуудлаар гүйцэтгэх захиралтай шууд харьцах эрхтэй.

#### **109.71. Байгууллагын Ерөнхий заавар**

- (а) ЗААБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах журмыг багтаасан Ерөнхий зааврыг Даргаар хүлээн зөвшөөрүүлэхээр хүргүүлэх үүрэгтэй:
- (1) тухайн хүсэлт гаргагчийн байгууллагын нэрийн өмнөөс гүйцэтгэх захирал гарын үсэг зурсан дараах мэдэгдэл:
    - (i) Ерөнхий заавар нь тухайн байгууллагыг тодорхойлсон ба энэ Дүрмийн байнгын хэрэгжилтийг бататгах хэлбэр болон аргыг харуулсныг бататгах;
    - (ii) Ерөнхий заавар болон холбогдох бүх заавар, үйл ажиллагааны болон аюулгүйн хамгаалалтын хяналтын журмыг байгууллагын ажилтнууд байнга дагаж мөрдөх үүрэгтэйг бататгах.
  - (2) 109.51(а)(1) болон (2)-т заасан удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтнуудын албан тушаал болон нэр;
  - (3) тухайн байгууллагын нэрийн өмнөөс Даргатай шууд харьцах асуудлыг багтаасан, энэ хэсгийн (2)-т заасан удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтнуудын үүрэг, хариуцлага;
  - (4) энэ хэсгийн (6)-д заасан байрлал тус бүрийг хамарсан, энэ хэсгийн (2)-т заасан удирдах ажилтнуудын хариуцлагын шугаман хамаарлыг харуулсан байгууллагын бүтцийн зураг;
  - (5) энэ хэсгийн (6)-д заасан байрлал бүр дэх, тухайн байгууллагын ажилтнуудын бүтцийн хураангуй мэдээлэл;
  - (6) ачаа болон шуудантай холбоотой аюулгүйн хамгаалалтын хяналт гүйцэтгэх тухайн байгууллагын ажилтнуудын байрлал бүрийн үйл ажиллагааны хамрах хүрээний хураангуй мэдээлэл;
  - (7) 109.53-ын шаардлага хангасан, энэ хэсгийн (6)-д заасан байрлал бүрийн байгууламжийн хураангуй мэдээлэл;
  - (8) 109.69-д шаардсан, дотоод чанар баталгаажуулалтын талаарх нарийвчилсан журам;

(9) дараах зүйлээр шаардсан нарийвчилсан журмууд, эсхүл нарийвчилсан журмыг багтаасан баримт бичгийг тодорхойлох мэдээллийг агуулсан журмуудын бүдүүвч:

- (i) 109.51(b) - ажилтны ур чадварын талаар;
- (ii) 109.55(a)(1) - бүртгэлгүй харилцагчаас хүлээн авсан ачаа, эсхүл шууданг аюулгүйн хамгаалалтын хяналтад хамруулах талаар;
- (iii) 109.55(a)(2) болон (3) - бүртгэлтэй харилцагчаас ачаа, эсхүл шуудангаар илгээх барааг хүлээн авах талаар;
- (iv) 109.55(a)(4) - ачаа, эсхүл шуудангаар илгээх барааг хяналттай нэвтрэх бүсэд хадгалах талаар;
- (v) 109.55(a)(5)(i) - агаарын тээвэрлэгчид хүргүүлэх ачаа, эсхүл шуудангаар илгээх барааны аюулгүйн хамгаалалтын мэдүүлгийн бүрдүүлэлтийн талаар;
- (vi) 109.55(a)(5)(ii) - тухайн илгээх барааг агаарын тээвэрлэгчид хүргүүлэх үед ачаа, эсхүл шуудангаар илгээх бараанд гэмтэл учруулах үйлдлээс хамгаалах талаар;
- (vii) 109.57 - ачаа, эсхүл шууданд аюулгүйн үзлэг хийх талаар;
- (viii) 109.59 - ажилтнуудад зөвшөөрөл олгох талаар;
- (ix) 109.61 - бүртгэлтэй харилцагчид тавих шаардлагын талаар;
- (x) 109.63 - сургалтын хөтөлбөрийн талаар;
- (xi) 109.65(1) - ачааны аюулгүйн хамгаалалтын зөрчлийг мэдээлэх, шинжлэн шалгах болон тайлагнах талаар;
- (xii) 109.65(2) - ачааны аюулгүйн хамгаалалтын зөрчлийн шалтгааныг арилгах залруулах арга хэмжээ авах болон давтагдахаас сэргийлэх талаар;
- (xiii) 109.67 - бүртгэлийг таньж тогтоох, цуглуулах, индексжүүлэх, хадгалах, хөтлөх болон устгах талаар;

(10) дараах журмын дэлгэрэнгүй мэдээлэл:

- (i) Ерөнхий зааврыг хянах, нэмэлт өөрчлөлт оруулах болон түгээх;
- (ii) Ерөнхий заавар нь энэ Дүрмийн холбогдох шаардлагыг хангаж байгааг бататгах;
- (iii) Ерөнхий зааварт нэмэлт өөрчлөлт оруулсны дараа тухайн нэмэлт өөрчлөлт бүрийн хувийг Даргад цаг алдалгүй хүргүүлэхийг бататгах журам.

(b) Ерөнхий заавар нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц хэвээр байх ёстой.

## С Бүлэг - Үйл ажиллагааны шаардлага

### 109.101. Байнгын хэрэгжилт

ЗААБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах үүрэгтэй:

- (1) энэ Дүрмийн дагуу гэрчилгээжүүлэлтэд тавих В Бүлгийн шаардлагыг хэрэгжүүлэн, стандартыг байнга дагаж мөрдөх;
- (2) тухайн гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт заасан журам бүрийг дагаж мөрдөх;
- (3) байгууллагын Ерөнхий зааврын нэгээс доошгүй хүчинтэй хувийг Ерөнхий зааварт заасан удирдах ажилтны байрлал бүрд байлгах;
- (4) Ерөнхий зааврын холбогдох бүлэг бүрийг өөрийн үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ажилтанд хэрэглэх боломжтой байлгах;
- (5) тухайн гэрчилгээ эзэмшигчийн бүртгэлтэй харилцагч бүрийн хүчинтэй мэдээллийг агуулсан бүртгэлийг хөтлөх;
- (6) 109.103-г харгалзан, хэрэв Дарга бичгээр хүссэн бол гэрчилгээ эзэмшигчийн бүртгэлтэй харилцагчийн бүртгэлээс тухайн харилцагчийн нэрийг түдгэлзүүлэх, эсхүл хасах;
- (7) үйлчилгээний хаяг, утасны дугаар, эсхүл факсын аливаа өөрчлөлтийн талаар тухайн өөрчлөлтийг хийснээс хойш 28 хоногийн дотор Даргад бичгээр мэдэгдэх;
- (8) тухайн этгээд нь 109.59-д шаардсан журмын дагуу олгосон зөвшөөрөл эзэмшдэг байхаас бусад тохиолдолд гэрчилгээ эзэмшигчийн гэрчилгээний эрхийн хүрээнд аюулгүйн хамгаалалтын хяналтын үүрэг гүйцэтгэхгүй болохыг бататгах.

### 109.103. Бүртгэлтэй харилцагчийн нэрийг түдгэлзүүлэх, эсхүл хасах

(a) Энэ зүйлийн (c)-г харгалзан, хэрэв Дарга дараах нөхцөл үүссэн гэж үзвэл, бүртгэлтэй харилцагчийн нэрийг ЗААБ-ын гэрчилгээ эзэмшигчийн бүртгэлтэй харилцагчийн бүртгэлээс түдгэлзүүлэх, эсхүл хасах хүсэлтийг бичгээр гаргаж болно:

- (1) тухайн бүртгэлтэй харилцагч нь дараах шаардлагыг дагаж мөрдөөгүй бол:
  - (i) 109.55(a)(2), эсхүл (3)-т шаардсан, ачаа болон аюулгүйн хамгаалалтын хяналтын журамтай холбоотой шаардлага; эсхүл
  - (ii) 109.61-д шаардсан, бүртгэлтэй харилцагчийн бүртгэл болон журамтай холбоотой шаардлага;
- (2) тухайн бүртгэлтэй харилцагчийн нэрийг түдгэлзүүлэх, эсхүл хасах нь нисэхийн аюулгүйн хамгаалалтын ашиг сонирхолд нийцэж байгаа бол.

(b) Гэрчилгээ эзэмшигчийн бүртгэлтэй харилцагчийн бүртгэлээс тухайн харилцагчийн нэрийг Даргын тогтоосон хугацаагаар, эсхүл тухайн харилцагчийн хангаагүй шаардлага бүрийг хангасныг Дарга хүлээн зөвшөөрөх хүртэл түдгэлзүүлж, эсхүл хасаж болно.

(c) Энэ зүйлийн (d)-г харгалзан, энэ зүйлийн (a)-ийн дагуу бүртгэлтэй харилцагчийн нэрийг хасах, эсхүл түдгэлзүүлэх хүсэлт гаргахын өмнө, хэрэв тухайн бүртгэлтэй харилцагчид хохирол учруулж болох, эсхүл болзошгүй аливаа мэдээлэлд анхаарал хандуулахыг санал болгож байгаа бол Дарга тухайн мэдээллийг бүртгэлтэй харилцагчид ил болгох ба мэдээллийг ил болгосноос хойш 30 хоногийн дотор хариулт, эсхүл няцаалт өгөх боломжийг бүртгэлтэй харилцагчид олгох үүрэгтэй.

(d) Дарга дараах тохиолдолд мэдээллийг ил болгохгүй:

- (1) аливаа этгээдийн аюулгүй байдалд аюул учруулж болзошгүй бол;
- (2) хэрэв ил болгох нь нисэхийн аюулгүйн хамгаалалтын ашиг сонирхолд нийцэхгүй бол.

#### **109.105. Гэрчилгээ эзэмшигчийн байгууллагын өөрчлөлт**

(a) Энэ зүйлийн (b)-г харгалзан, ЗААБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах үүрэгтэй:

- (1) Ерөнхий зааврын нэмэлт өөрчлөлтийг, тухайн гэрчилгээ эзэмшигчийн байгууллагын тодорхойлолт хүчинтэй ба агаарын ачааны аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ хэвээр хадгалагдаж байхаар хийснийг бататгах;
- (2) Ерөнхий зааварт оруулсан нэмэлт өөрчлөлт нь энэ Дүрмийн холбогдох шаардлагыг хангаж байгааг бататгах;
- (3) Ерөнхий зааврын нэмэлт өөрчлөлт оруулах журмыг дагаж мөрдөх;
- (4) Ерөнхий зааварт нэмэлт өөрчлөлт оруулсны дараа, Даргын хэрэгцээнд зориулж, нэмэлт өөрчлөлт бүрийн хувийг цаг алдалгүй хүргүүлэх;
- (5) Дарга нисэхийн аюулгүйн хамгаалалтын ашигт сонирхолд шаардлагатай гэж үзсэн нэмэлт өөрчлөлтийг Ерөнхий зааварт оруулах.

(b) Хэрэв ЗААБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах аль нэг өөрчлөлтийг хийж байгаа, эсхүл хийхээр санал болгож байгаа бол гэрчилгээ эзэмшигч нь тухайн өөрчлөлтийг хийхийн өмнө, эсхүл хэрэв урьдчилан мэдэгдэх боломжгүй бол Даргад цаг алдалгүй мэдэгдэх үүрэгтэй бөгөөд, холбогдох тохирох зөв хүний шалгуурыг багтаасан өөрчлөлтийг гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт оруулахын өмнө Дарга хүлээн зөвшөөрсөн байх ёстой:

- (1) гүйцэтгэх захирлаар тодорхойлогдсон этгээд;
- (2) 109.71(a)(2)-т шаардсаны дагуу, Ерөнхий зааварт заасан удирдах ажилтны нэр, эсхүл албан тушаал;
- (3) 109.55-д шаардсан ачаа болон шуудангийн аюулгүйн хамгаалалтын журам;
- (4) 109.57-д шаардсан аюулгүйн үзлэгийн журам;
- (5) 109.59-д шаардсан зөвшөөрөл олгох журам;



- (6) 109.61-д шаардсан бүртгэлтэй харилцагчийн журам;
- (7) 109.69-д шаардсан дотоод чанар баталгаажуулалтын журам.

(c) Дарга, энэ зүйлийн (b)-д заасан аливаа өөрчлөлтийг оруулах үед, эсхүл оруулсны дараа ЗААБ-ын гэрчилгээ эзэмшигчийн заавал дагаж мөрдөх нөхцөлийг тогтоож болно.

(d) ЗААБ-ын гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (c)-ийн дагуу Даргын тогтоосон аливаа нөхцөлийг дагаж мөрдөх үүрэгтэй.

(e) Хэрэв энэ зүйлийн (b)-ийн дагуу хийсэн аливаа өөрчлөлт нь ЗААБ-ын гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулахыг шаардсан бол гэрчилгээ эзэмшигч нь өөрчлөлтийг баталгаажуулсан тэмдэглэл хийлгэхээр тухайн гэрчилгээг Даргад цаг алдалгүй хүргүүлэх үүрэгтэй.

### **109.107. Аюулгүйн хамгаалалтын мэдүүлэг гаргах этгээд**

Дараахаас бусад тохиолдолд аливаа этгээдийг энэ Дүрэмд хамаарах ачаа, эсхүл шуудангаар илгээх барааны аюулгүйн хамгаалалтын мэдүүлгийг агаарын тээвэрлэгчид гаргаж өгөхийг хориглоно:

- (1) тухайн этгээд нь ЗААБ-ын гэрчилгээ эзэмшигчээс бичгээр олгосон мэдүүлэг гаргах хүчинтэй зөвшөөрөл эзэмшдэг байх;
- (2) тухайн этгээд нь аюулгүйн хамгаалалтын мэдүүлгийг:
  - (i) ЗААБ-ын гэрчилгээний эрхийн хүрээнд гаргадаг байх;
  - (ii) гэрчилгээ эзэмшигчийн мэдүүлэг гаргах журмын дагуу гаргадаг байх;
- (3) тухайн ачаа, эсхүл шуудангаар илгээх бараа нь гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт дэлгэрэнгүй заасан аюулгүйн хамгаалалтын хяналтын журамд заасан байх.

### **109.109. Хяналттай нэвтрэх бүс рүү нэвтрэх**

ЗААБ-ын гэрчилгээ эзэмшигч нь аливаа этгээдэд хяналттай нэвтрэх бүсэд нэвтрэхийг зөвшөөрөхгүй ба дараахаас бусад тохиолдолд аливаа этгээдийг түүнд нэвтрэхийг хориглоно:

- (1) тухайн этгээд нь 109.59(b)-д шаардсан журмын дагуу бичгээр олгосон хүчинтэй зөвшөөрөлтэй байх; эсхүл
- (2) тухайн этгээдийг энэ хэсгийн (1)-д заасан зөвшөөрөл эзэмшдэг этгээд дагалдаж байх.

## Хавсралт А - Аюулгүйн хамгаалалтын мэдүүлэг

### А.1. Аюулгүйн хамгаалалтын мэдүүлэг

Аюулгүйн хамгаалалтын мэдүүлэг нь тодорхой ачаа, эсхүл шуудангаар илгээх бараанд хамааралтай байх ба дараах мэдээллийг агуулсан байх ёстой:

- (1) тухайн мэдүүлгийг аль ЗААБ-ын гэрчилгээний хүрээнд гаргасныг таньж тогтоох;
- (2) тухайн илгээх барааг хүргэх цэг;
- (3) тухайн илгээх барааг хүргүүлсэн агаарын тээвэрлэгчийг таних;
- (4) тухайн илгээх барааг агаарын тээвэрлэгчид хүргүүлсэн огноо;
- (5) тухайн илгээх бараа нь энэ Дүрэм болон ЗААБ-ын Ерөнхий зааврын дагуу ачааны аюулгүйн хамгаалалтын хяналтад хамрагдсан бөгөөд энэ хэсгийн (8)-д зааснаас бусад тохиолдолд аливаа зэвсэг, тэсрэх бодис, эсхүл бусад аюултай бараа илрээгүй тухай мэдүүлэг;
- (6) мэдүүлэг гаргахаар зөвшөөрөгдсөн этгээдийг таньж тогтоох нэр, гарын үсэг;
- (7) хуурамч мэдүүлэг гаргах нь гэмт хэрэг болохыг мэдэж байгаа тухай мэдэгдэл;
- (8) тухайн илгээх бараанд агуулагдаж байгаа аливаа зэвсэг, тэсрэх бодис, эсхүл бусад аюултай барааны жагсаалт.

## Хавсралт В - Аюулгүйн үзлэгийн стандарт

### В.1. Аюулгүйн үзлэгийн арга

(a) Аюулгүйн үзлэг хийсэн, эсхүл үзлэг хийсэн байх шаардлагатай ачаа, эсхүл шууданд дараах аль нэг, эсхүл хэд хэдэн аргыг ашиглан аюулгүйн үзлэг хийж болно:

- (1) ердийн рентген төхөөрөмж (x-ray);
- (2) тэсрэх бодис илрүүлэх дэвшилтэт технологийн рентген систем (AT-EDS);
- (3) тэсрэх бодисын ул мөр илрүүлэх систем (ETD);
- (4) тэсрэх бодис илрүүлэх нохой;
- (5) компьютер томограф;
- (6) биет шалгалт;
- (7) Даргын хүлээн зөвшөөрөхүйц аюулгүйн үзлэгийн бусад арга, эсхүл технологи.

(b) Аюулгүйн үзлэгийн төхөөрөмж нь хяналттай нэвтрэх бүсэд байрласан байх ёстой.

## **В.2. Үечилсэн сорилт**

- (a) Аюулгүйн үзлэгийн арга бүрээр тухайн үзлэгийн үйл явцын байнгын тохирлыг бататгах, сорилын биетийг ашигласан үечилсэн сорилт хийдэг байх ёстой.
- (b) Сорилын биет нь:
- (1) сорьж байгаа тухайн аюулгүйн үзлэгийн аргад тохирсон байх;
  - (2) тухайн аюулгүйн үзлэгийн аргаар илрүүлэхэд зориулагдсан, зөвшөөрөгдөөгүй эд зүйлийн төлөөлөл байх;
  - (3) Даргын хүлээн зөвшөөрөхүйц байх ёстой.
- (c) Хэрэв үечилсэн сорилт нь аюулгүйн үзлэг хийж байгаа этгээдийн ур чадварыг шалгахыг зорьж байгаа бол тухайн сорилтыг дараах байдлаар хийх ёстой:
- (1) тухайн аюулгүйн үзлэгийг гүйцэтгэж байгаа этгээдэд урьдчилан мэдэгдэхгүйгээр;
  - (2) тухайн сорилтод ашиглаж байгаа сорилын биетийг аюулгүйн үзлэг хийгдэж байгаа ачаа, эсхүл шуудангийн бусад эд зүйлсийн хамт байрлуулж;
  - (3) тухайн сорилын биетийг илрүүлэх боломжийг сорилтод хамрагдаж байгаа этгээдэд олгосон хэлбэрээр.

## **Хавсралт С - Сургалтын Стандарт**

### **С.1. Үнэлгээний тогтолцоо болон сургалт**

- (a) Энэ зүйлийн (b)-д заасан ур чадварын түвшний үнэлгээний тогтолцоо нь дараах үнэлгээнээс бүрдэнэ:
- (1) Үнэлгээ 1 - тухайн сэдвийн ойлголтыг харуулах;
  - (2) Үнэлгээ 2 - тухайн сэдвийн суурь мэдлэгийг харуулах;
  - (3) Үнэлгээ 3 - тухайн этгээдийн ажил үүргээ гүйцэтгэх явцад үүсэж болзошгүй нөхцөлд тухайн сэдвийн суурь мэдлэгээ ашиглах чадварыг харуулах;
  - (4) Үнэлгээ 4 - тухайн этгээд нь ажил үүргээ гүйцэтгэх явцад үүсэж болзошгүй нөхцөлд тухайн сэдвийн гүнзгий мэдлэгээ ашиглах чадварыг харуулах;
  - (5) Үнэлгээ 5 - тухайн этгээд нь ажил үүргээ гүйцэтгэх явцад үүсэж болзошгүй нөхцөлд тухайн сэдвийн гүнзгий мэдлэг болон нөхцөл байдлыг зөв тодорхойлж илэрхийлэх чадварыг харуулах.
- (b) Аюулгүйн үзлэгийн үүрэг гүйцэтгэх ажилтны сурсан байхыг шаардсан дараах сэдвүүд:
- (1) **Ачаа, эсхүл шууданд аюулгүйн үзлэг болон хайлт хийх:**
    - (i) Үнэлгээ 4 - ачаанд аюулгүйн үзлэг болон хайлт хийх зохицуулалтын үндсэн зарчмыг тоймлох;

- (ii) Үнэлгээ 5 - тухайн гэрчилгээ эзэмшигчийн ашигладаг аюулгүйн үзлэгийн төхөөрөмжийг мэддэг, мэргэжлийн ур чадвартай ашигладаг байх;
  - (iii) Үнэлгээ 5 - ачаанд аюулгүйн үзлэг болон хайлт хийх журам болон аргыг хэрэглэх туршлагатай байх.
- (2) **Гар хийцийн тэсрэх төхөөрөмж:** Үнэлгээ 3 - иргэний нисэхэд нөлөөлөх ачаа, эсхүл шууданд илэрч болох гар хийцийн тэсрэх төхөөрөмжийн талаарх ойлголтыг аюулгүйн үзлэг гүйцэтгэх этгээдэд өгөх.
- (3) **Заналхийллийн хүчин зүйл:** Үнэлгээ 2 - аюулгүйн үзлэг хийж байгаа этгээдэд өнөөгийн терроризм болон гэмт хэргийн чиг хандлагын талаарх мэдээллийг шинэчлэх.
- (4) **Хууль бус үйлдэл хийсэн түүхэн баримт болон статистик:** Үнэлгээ 1 - нисэхийн аюулгүйн хамгаалалтын хөгжил болон хэрэг явдлын тархцын талаарх мэдлэгийг ажилтнуудад олгох.

--oOo--